

ДСЦТС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2024.04.30

Цаг: 11:00-12:15

Байршил: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 11 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо "Хасвуу Плаза"- гийн хурлын танхимд

Хурлын дарга: Ц.Баярбаатар

Тооллогын комиссын дарга: Г.Бэхбат

Тооллогын комиссын гишүүн, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга: М.Баярманла

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн ирц: 100 хувь

Саналын эрхтэй хувьцааны тоо: 10,385,116

Хэлэлцэх асуудал

1. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны үр дүнгээс ногдол ашиг хувиарлахгүй тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах;
3. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох;
4. Компанийн ТУЗ-ийн 2024-2025 оны ТУЗ-ийн цалин урамшуулал болон зардлыг батлах;
5. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах.

Тооллогын комиссын дарга Г.Бэхбат: "Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани (цаашид "Компани" гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт саналын эрхтэй энгийн хувьцааны (1) 77 хувь буюу 7,996,539 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг эзэмшигч "Хасвуу" ХХК; (2) 18 хувь буюу 1,869,320 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг эзэмшигч С.Нэргүй; (3) 5 хувь буюу 519,256 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг эзэмшигч Хас Энержи ПиТиЕэ Лтд (Khas Energy Pte Ltd) нар буюу хувьцаа эзэмшигчдийн 100 хувь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн байна.

Түүнчлэн Компанийн тухай хуулийн 83.8-д заасны дагуу Хасвуу ХХК-г итгэмжлэлгүй төлөөлөх этгээд нь түүний гүйцэтгэх захирал С.Нэргүй болох нь тус компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээгээр нотлогдож байгааг; иргэн С.Нэргүй нь тус хуралд өөрийн биеэр ирсэн болохыг түүний Монгол Улсын иргэний үнэмлэхээр нотлогдож байгааг; түүнчлэн эзэмшигч Хас Энержи ПиТиЕэ Лтд (Khas Energy Pte Ltd) -ийг төлөөлж, түүнийг

үүсгэн байгуулагч ДСЦТС ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Хангай итгэмжлэлийн дагуу оролцож байгааг; С.Нэргүй болон Ц.Хангай нар нь 2023 оны 05 дугаар сараас - 2024 оны 04 сарыг дуустал ДСЦТС ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байгааг тус тус тэмдэглэв.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ын ирц 100 хувьтай бүрдсэн болохыг Хурлын дарга болон Компанийн хувьцаа эзэмшигчдэд мэдээлж байна” гээд хурлын ажиллагаанд Тооллогын комииссын дарга амжилт хүсэв.

Хэлэлцэх асуудал нэг

Ц.Баярбаатар тус компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийн хамт танилцуулав.

Түүнчлэн 2023-24 оны ТУЗ-д Хараат бус гишүүнээр: Ц.Баярбаатар (ТУЗ-ийн дарга), Г.Бэхбат, Л.Балган нар; Ердийн гишүүдээр: Ц.Хангай (Гүйцэтгэх захирал), С.Нэргүй (Дэд захирал), Э.Долгорсүрэн, Н.Эрдэнэбат, Т.Энхмэнд, Б.Эрдэнэбилэг нар, Нарийн бичгийн даргаар М.Баярманла нар ажилласан. Дээрх бүрэлдэхүүнээс: Аудитын хороонд Л.Балган (дарга), Г.Бэхбат, Э.Долгорсүрэн нар; Нэр дэвшүүлэх хороонд Ц.Баярбаатар (дарга), Г.Бэхбат, Ц.Хангай; цалин урамшуулалын хороонд Г.Бэхбат (дарга), Л.Балган, Ц.Хангай нар ажилласан болохыг тэмдэглэв.

Нийт хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болох С.Нэргүй, Ц.Хангай нар ТУЗ-ийн гишүүдээр томилогдон ажилласан болохыг мөн тэмдэглэв.

Тогтоолын төсөл: Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн тайланг хэлэлцэн батлах

Зөвшөөрсөн: 100 хувь буюу нийт саналын эрхтэй хувьцаа: 10,385,116

Татгалзсан: 0

Түдгэлзсэн: 0

Хэлэлцэх асуудал хоёр

Ц. Баярбаатар компанийн 2023 оны үйл ажиллагааны үр дүнгээс ногдол ашиг олгохгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулав.

Хэлэлцэх асуудал гурав

Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох

М.Баярманла компанийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийг танилцуулав.

Кумалатив аргаар ердийн болон хараат бус гишүүдийг сонгох зааварчилгааг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Санал хураалтын дүнг Тооллогын комиссын дарга Г.Бэхбат танилцуулав. Үүнд:

Хараат бус гишүүдэд нэр дэвшсэн: (i) Нүдэнгийн Эрдэнэбатад нийт саналын эрхийн 11,11 хувь буюу 1,153,901 ширхэг санал, (ii) Галсангийн Бэхбатад нийт саналын эрхийн 11,11 хувь буюу 1,153,901 ширхэг санал, (iii) Цэндсүрэнгийн Баярбаатарт нийт саналын эрхийн 11,11 хувь буюу 1,153,901 ширхэг санал, (iv) Нямдаваагийн Монсорт нийт саналын эрхийн 11,11 хувь буюу 1,153,901 ширхэг санал, (v) Жамсрандоржийн Дэлгэрсайханд нийт саналын эрхийн 11,11 хувь буюу 1,153,901 ширхэг санал тус тус өгөв.

Ердийн гишүүнд нэр дэвшүүлсэн (i) Буянзаяагийн Эрдэнэбилэгт нийт саналын эрхийн 11,11 хувь буюу 1,153,901 ширхэг санал, (ii) Түмэнжаргалын Энхмэндэд нийт саналын эрхийн 11,11 хувь буюу 1,153,901 ширхэг санал, (iii) Самдангийн Нэргүйд нийт саналын эрхийн 11,11 хувь буюу 1,153,901 ширхэг санал, (iv) Цэнгэлийн Хангайд нийт саналын эрхийн 11,11 хувь буюу 1,153,901 ширхэг санал тус тус өгсөн болохын тэмдэглэв.

Хараат бус гишүүдэд нэр дэвшсэн Лумаагийн Балган, ердийн гишүүнд нэр дэвшсэн Энэбишийн Долгорсүрэн нарт санал өгсөнгүй.

ТУЗ-ийн Хараат бус гишүүдэд шинээр нэр дэвшсэн Н.Монсор, Ж.Дэлгэрсайхан нарыг шинээр томилж байна. Бусад ТУЗ-ийн гишүүд кумалатив санал хураалтын үр дүнгээр улиран томилогдож байна.

Хэлэлцэх асуудал дөрөв

Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2022-2023 оны цалин урамшуулал болох зардлыг батлах

Тогтоолын төслийг танилцуулав. ТУЗ-ийн төсвийн төсөлийг Компанийн гүйцэтгэх удирдлагаас санал авсны үр дүнд ТУЗ-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд танилцуулж байгааг тэмдэглэв.

Тогтоолын төсөл батлах санал хураалтаар

Зөвшөөрсөн: 100 хувь буюу нийт саналын эрхтэй хувьцаа: 10,385,116

Татгалзсан: 0

Түдгэлзсэн: 0

Хэлэлцэх асуудал тав.

Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах

Тогтоолын төслийг танилцуулав. ТУЗ-ийн зүгээс Дүрмийн төслийг Компанийн гүйцэтгэх удирдлагын саналаар ТУЗ-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд танилцуулж байгааг тэмдэглэв. Төслийг Компанийн Захиргаа удирдлагын хэлтэсийн дарга Чинцогт танилцуулав.

Тогтоолын төсөл батлах санал хураалтаар

Зөвшөөрсөн: 100 хувь буюу нийт саналын эрхтэй хувьцаа: 10,385,116

Татгалзсан: 0


Түдгэлзсэн: 0

Хурлын дарга хуралд оролцогсдод талархал илэрхийлснээр хурал 12 цаг 25 минутад өндөрлөв.


Тэмдэгдэл хөтөлсөн Нарийн бичгийн дарга:

 М.Баярманла

Танилцсан Хурлын дарга:

 Ц.Баярбаатар

Тооллогын комиссын дарга:

 Г.Бэхбат

Тооллогын комиссын гишүүн, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

 М.Баярманла

